

Батлав.....

УЛСЫН ШАЛГАЛТ - 2018

МОНГОЛ ХЭЛ-5

Аймаг / дүүрэг:
Сум
Сургууль:
Анги: Бүлэг:
Овог:
Нэр:

САНАМЖ, ЗӨВЛӨГӨӨ

- Шалгалт 60 минут үргэлжилнэ.
- Шалгалтын материал хоёр хэсэгтэй ба нэгдүгээр хэсэг нь унших чадвар сорьсон холимог хэлбэрийн, хоёрдугаар хэсэг нь бичих чадвар сорьсон задгай хэлбэрийн даалгавраас бүрдэнэ.
- Нэгдүгээр хэсгийн сонгох хэлбэрийн даалгаврын хариултаас зөв гэж үзсэн нэг хариултын харгалзах үсгийг сонгон дугуйлаарай.
- Даалгавар бүрийн хариултыг өгөгдсөн зайд бичиж тэмдэглэнэ.

ТА БҮХЭНД АМЖИЛТ ХҮСЬЕ

Цэцгийн үр

Нарлаг зуны сайхан өдөр есдүгээр байрны гадаах талбайд хүүхдээ салхилуулах ээжүүд, ач зээгээ харах эмээ өвөө нар, хэд хэдээрээ нийлэн дуу хөгжим сонсож, утсаа оролдсон хөвгүүд охид тэгээд бас энд тэндгүй гүйлдэх том жижиг хүүхдүүд гээд түм түжигнэж, бум бужигнаж байв.

Хэнийх гэдгийг нь мэдэхгүй нэгэн гэр бүлийнхэн байрныхаа гадаа цэцгийн үр суулгаж, хэд хэдэн мод тарив. Гэрийн эзэн хүрээр газар малтаж, том савтай ус зөөж харагдана. Гэргий нь гялгар уутаар үндсийг нь боосон нарийхан мөчир, тэгээд бас гоё гоё ууттай цэцгийн үрийг нямбайлан суулгаж, долоогоос найман настай хүү нь ээж аавдаа тусална.

Тэдний юу хийж байгааг харж суусан хүмүүсийн зарим нь “Ингээд нэмэргүй дээ, сахилгагүй хүүхдүүд дор нь гишгээд хаяна” гэж хүүхдүүд рүү муухай харна. Нөгөө нэг нь огт тоосон шинжгүй байхад харин үлдсэн хэсэг нь өнөөх гэр бүлийнхнийг гоочилж өмссөн зүүсэн, үс зүснийх нь тухай шивэр авир гэнэ. Хэн ч тэдэнд тусалсангүй, хэн ч тэдэнд урмын үг хэлсэнгүй. Эхний өдөр ингээд өнгөрөв.

Маргааш нь нээрээ л өнөөх гэр бүлийнхний суулгасан мөчрүүд унасан гэмтсэн, хугарсан, үр цацсан хөрс нь талхлагдсан харагдав. Ажил тараад удаагүй байтал өнөөх гэр бүлийнхэн маань дахин гарч ирээд өчигдрийн суулгасан модны мөчрүүдээ үзэж, дахин суулгаж, цэцгийн үр цацсан хөрсөө услан тордож эхлэв. Өчигдөр тэднийг үгүйсгэж байсан хүмүүс өнөөдөр тэднийг шоолох янзтай мушилзана. Дахиад нэг өдөр өнгөрөв. Өмнөх хоёр өдрийн үйл явдал давтагдахад харж суусан хүмүүс харин өнөөх гэр бүлийн өмнөөс харамсан халаглаж, өрөвдөж хөөрхийлөв. Гэсэн ч тэд огт шантрахгүйгээр модоо усалж, цэцгийн үр суулгасан хөрсөө хамгаална. Дахиад нэг өдөр өнгөрөхөд гэрийн эзэгтэй бүр олон мөчир авчирсан байв.

Хэн ч хүчлээгүй байхад хүүхдүүд тэдэнд тусалж эхлэв. Дараагийн өдөр болоход хүмүүсийн ихэнх нь тэдэнтэй хамтрав. Ийнхүү долоо хоног өнгөрөхөд нөгөө гэр бүлийнхний тарьсан мод, цэцгийн үртэй хөрсийг хэн ч сэндийлэхээ болив. Арав хоногийн дараа гэхэд энэ хавийнхан бүгд өнөөх моддыг, үр суулгасан хөрсийг хамгаалдаг болсон байв. Харин сарын дараа тэр байрны гадаах бүх хүн нахиалан ургасан мөчрүүдийг, соёолж эхэлсэн цэцгийн үрийг харан, инээж хөөрч, өөрсдөө тарьсан мэт баярлан догдолж, бие биенээсээ өрсөн усалж тордон, ойр орчмынх нь хогийг түүдэг болсон юм.

Нэгэн гэр бүлийн тууштай, тэвчээртэй, уужуу тайван, ухаалаг зөв хандлага ийнхүү олон хүнийг өөрчилсөн. Энэ байрны гадаа итгэл найдвар, эв нэгдэл, эрүүл саруул сэтгэл сэтгэлгээ мододтой цуг, цэцэгстэй цуг ургаж эхэллээ. Хүмүүс ярвайж биш инээмсэглэн алхах нь анзаарагдана.

Одоо есдүгээр байрны гадаах орчин маш сайхан болсон. Байшингийн гадаа мод ургаж цэцэг дэлгэрлээ. Хүмүүсийн сэтгэл ухаанд ч бас ийм сайхан цэцэгс урган төлжиж эхлэв. Гадаад ертөнц өөрчлөгдөхөд түүнийг дагаад дотоод ертөнц бас хувьсдаг юм байна.

Д.Нарантуяа

УНШИХ ЧАДВАРЫГ СОРЬСОН ДААЛГАВАР:

1. **түм түжигнэж, бум бужигнаж** - гэсэн үгийн утгад тохирох хэсгийг сонгоно уу.
A. маш олон хүүхэд инээх
B. маш олон хүн цуглах
C. маш олон цэцэг суулгах
D. маш олон хүн суух
2. **"эрвийх дэрвийхээрээ"** гэсэн хэлц үгийн утгад тохирох хэсгийг сонгоно уу.
A. биеийн амрыг харах
B. бусдад туслах
C. чадлаараа, байгаа бүхнээрээ хичээх
D. эзэн хичээвэл заяа хичээнэ
3. "Утсаа оролдсон **хөвгүүд охид**, энд тэндгүй гүйлдэх **том жижиг** хүүхдүүд байна." тодруулсан үгс ямар утгатай холбоо үг вэ?
A. ойролцоо утгатай үг
B. салаа утгатай үг
C. шилжсэн утгатай үг
D. эсрэг утгатай үг
4. **"Нэгэн гэр бүлийн тууштай хөдөлмөрийн байрны гадаах орчин сайхан болсон."** гэсэн өгүүлбэрийн цэгийн оронд тохирох холбох үгийг сонгоно уу.
A. дараа
B. учраас
C. үр дүнд
D. эцэст нь
5. Тэр гэр бүлийнхний хийсэн үйлийг цаг хугацаагаар нь зөв дараалуулсан хэсгийг олоорой.
1. Маргааш нь мөчрүүд унаж гэмтэж ч дахин суулгаж тордсон.
2. Хэн ч тусалсангүй, хэн ч тэдэнд урмын үг хэлсэнгүй.
3. Нэгэн гэр бүлийнхэн цэцгийн үр суулгаж, хэдэн мод тарив.
4. Сарын дараа өөрсдөө тарьсан мэт баярлан догдолсон.
A. 1, 2, 3, 4 B. 2, 3, 1, 4 C. 3, 2, 1, 4 D. 3, 1, 4, 2
6. Нэгэн гэр бүлийнхэн байрны гадаа юу хийж байсан бэ?
A. Хүүхдээ салхилуулж байсан.
B. Цэцгийн үр суулгаж, мод тарьсан.
C. Цэцгийн үр суулгаж, хөгжим сонссон.
D. Энд тэндгүй гүйлдэж байсан.
7. Өмнөх хоёр өдрийн үйл явдал давтагдахад хүмүүс яаж хандсан бэ?
A. Харамсан халаглаж өрөвдсөн.
B. Шоолох янзтай мушилзсан.
C. Огт тоосон шинжгүй байсан.
D. Тэдэнд очиж тусалсан.
8. Яагаад? Ямар учраас гэсэн асуух үг ашиглан нэгэн гэр бүлийнхэн мод тарих болсон шалтгааныг илрүүлэх 1 асуулт зохиогоорой.
.....
.....
.....

-
9. Тэр гэр бүлийнхний зөв хандлагуудаас 3-ыг тоочин бичнэ үү?

-
-
-

10. **дэм дэмэндээ** гэсэн хэлц үгийн утгыг тайлбарлан, хэлц үгээ оролцуулан өгүүлбэр зохиож бичээрэй.

Хэлц үгийн тайлбар:

.....

Өгүүлбэр:

.....

11. **"Хүмүүс ярвайж биш инээмсэглэн алхах болсон."** өгүүлбэрт хүмүүс инээмсэглэн алхах болсон гэсэн үгээр зохиогч ямар санааг илэрхийлсэн бэ?

Учир шалтгаан:

Зохиогчийн санаа:

12. Дараах хоёр өгүүлбэрийн утгыг харьцуулж, дүгнэн бичнэ үү.

Байшингийн гадаа мод ургаж цэцэг дэлгэрлээ.	Хүмүүсийн сэтгэл ухаанд ч бас ийм сайхан цэцэгс урган төлжиж эхлэв.
.....	
.....	
Дүгнэлт:	
.....	

[illegible]

БИЧИХ ЧАДВАРЫН ДААЛГАВАР

Ангийнхандаа хандаж "Хоггүй сургууль аянд нэгдэцгээе" сэдвээр 120-150 үгэнд багтаан уриалж бичээрэй.

Эхлэл хэсэгт: - Тус аяныг хаанаас ямар зорилгоор зохион байгуулж байгаа тухай

Гол хэсэгт: - Хог хаяхгүй байх ямар ач тустай болох талаар бичих

Төгсгөл хэсэгт: - Тус аянд нэгдэн идэвхтэй оролцохыг уриалж бичих

This image shows a full page of a document template designed for handwritten notes or answers. It features approximately 28 evenly spaced horizontal dotted lines across the entire width of the page, providing a guide for letter height and placement. The background is plain white, and there are no margins, headers, or footers visible.

Handwriting practice lines consisting of 30 horizontal dotted lines.

Handwriting practice lines consisting of 30 horizontal rows. Each row is composed of three dotted lines: a top line, a middle line, and a bottom line, providing a guide for letter height and placement.

Handwriting practice lines consisting of 30 horizontal rows. Each row is composed of three dotted lines: a top line, a middle line, and a bottom line, providing a guide for letter height and placement.